



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/109

Бат-Өлзий сум

Трактор хүлээн авах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газарт Хөдөө ах ахуй, газар тариаланд шаардлагатай трактор (анжис, борной, төмс үрлэгч) хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Н.Түвшин (Бэлчээр, газар тариалан хариуцсан
мэргэжилтэн)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

М.Бат-Өлзий (Засаг даргын Тамгын газрын жолооч)

Х.Нямлхагва (иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
төлөөлөгч)

Б.Хэнчиш (иргэний төлөөлөл)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, гэрээнд заасан шалгуурыг хангасан тохиолдолд хүлээн авч, акт үйлдэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн газар тариалангийн зориулалттай тракторыг Засаг даргын Тамгын газрын өмчийн бүртгэлд бүртгэж, ашиглалт хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам), өмч хамгаалах зөвлөл (Э.Дашдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



My Doc Zakhiramj /ZD/ 2023

6 2 2 3 0 1 2 2 4